



ГЭМТЭЛ СОГОГ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ

16094 Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 31-р хороо
Дилав хутагт Жамсрангийн гудамж
Утас/Факс: (976) 70187795
И-мэйл: ncto@gemtel.mn

2024.06.25 № 02/888
танай _____-ны № _____-т


ТОДРУУЛГЫН ХАРИУ

Тус төвөөс зарласан ЭМЯ/20240102091 тоот Соронзон резонанст томографын аппарат худалдан авах тендер шалгаруулалтад ирүүлсэн тодруулгад хариу хүргүүлж байна.

Хавсралт 5... хуудас

ТЕНДЕРИЙН ҮНЭЛГЭЭНИЙ
ХОРООНЫ ДАРГА *[Signature]* Д.ЭНХБАЯР



№	ТОДРУУЛГЫН АСУУЛТ	ТОДРУУЛГЫН ХАРИУ
1. Техникийн үзүүлэлт		
1	<p>Энэ тендерт Helium free технологитой, бусад бүх үзүүлэлтүүд нь энэ тендерийн техник шаардлагуудыг хангах 1.5T MRI аппарат санал болгосон тохиолдолд энэ нь давуу тал болох уу? Учир нь тухайн технологийн MRI аппарат танай зарласан байгаа тендерийн 5.5 тэрбум төгрөгийн төсөвт багтах ч өмнө үеийн zero boil off технологиор хийгдсэн MRI аппаратуудаас үнэтэй тул бодлогоор дэвшилтэт технологийг дэмжихгүй бол үнээр илүү хямд байх боломж байхгүй.</p>	<p>1. Тендерийн техникийн шаардлагыг боловсруулахад мэргэжлийн боловсон хүчнээс бүрдсэн баг дэлхийд хүлээн зөвшөөрөгдсөн үйлдвэрлэгч нарын MRI аппаратуудыг интернетэд суурилсан мэдээлэл дээр тулгуурлан харьцуулсан байдлаар судалгаа хийж, түүнийгээ үндэслэл болгодог бөгөөд ямар аппарат үйлдвэрлэлтээс гарсан гараагүйг бид сайт дээрх мэдээлэл дээр үндэслэдэг. Учир нь эмнэлэг үйлдвэрлэгчийн мэдээллийг өөрөөр мэдэх боломжгүй юм. Мөн Philips үйлдвэрлэгийн сайт дээр Ingenia 1.5T загварын мэдээлэл өнөөдрийг хүртэл байсан учир тус тендерт дурдсан бөгөөд дараах линкээр нээлттэй орж шалгах боломжтой болно. www.philips.com/hk/healthcare/product/HC781315/ingenia-15t-evolution)</p>  <p>2. “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 12.4. “Техникийн тодорхойлолтод тодорхой нэг аж ахуй эрхлэгчийн бараа, үйлчилгээний худалдааны нэр, патент, түүнийг эзэмшигч, үйлдвэрлэгч, нийлүүлэгч, эсхүл үйлдвэрлэлийн арга, гарал үүслийг тухайлан заахыг хориглоно.” гэж заасны дагуу захиалагчийн зүгээс хуульд нийцүүлэн техникийн тодорхойлолтод шаардсан үзүүлэлтийг давуулж эсвэл дүйцүүлэн санал болгох нөхцөлийг бүрдүүлсэн бөгөөд дэлхийн MRI аппарат үйлдвэрлэгч бүх брэндүүд ижил тэгш өрсөлдөх боломжоор хангаж, бүгдэд нийцэхээр зарласан.</p>

		<p>Захиалагчийн зүгээс шаардсан техникийн шаардлагад нийцүүлэн ямар аппарат санал болгож, тус тендерт өрсөлдөх нь тухайн ханган нийлүүлэгч байгууллагын дотоод асуудал болно.</p> <p>3. Тендерийн техникийн шаардлагад аливаа нэг үйлдвэрлэгчийн бусад үйлдвэрлэгчээс ялгарах онцлогийг тусгаж, давуу эрх олгох нь хуулиараа хориотой учир нь одоогийн байдлаар гельгүй технологийг нэвтрүүлсэн Philips, Siemens 2-оос өөр дэлхийн брэнд үйлдвэрлэгч байхгүй (Toshiba/Canon, GE үйлдвэрлэгч нарт байхгүй учраас өрсөлдөөн хязгаарлах учир дутагдалтай) ба Гельгүй технологитой MRI аппарат санал болгосон тохиолдолд техникийн шаардлагыг дүйцүүлэн хангасан гэж үнэлэхээс бусад байдлаар давуу тал болгож, үнэлэхгүй.</p>
<p>2. ТШЗ 20.1-д нийлүүлэх барааны хувьд үйлдвэрлэгч, гэрээт борлуулагчийн гэрээ, итгэмжлэл, эрх бүхий байгууллагаас олгосон барааны импортын лиценз, гарал үүслийн гэрчилгээ, барааны CE, ISO, GMP гэрчилгээ, мэргэжлийн байгууллагын чанарын лабораторийн шинжилгээ ирүүлэх шаардлагатай. /шаардлагатай баримт бичгийг баталгаат орчуулгын газраар орчуулуулж, байгууллагын тамга тэмдэг, гарын үсгээр баталгаажуулсан байх шаардлагатай/.</p>		
1	<p>Эрх бүхий байгууллагаас олгосон барааны импортын лиценз гэж шаардсан байна. Тус тендерийн дагуу нийлүүлэгдэх MRI аппаратыг оруулж ирэхэд иэрх бүхий байгууллагаас MRI аппарат дээр нэг удаагийн импортын лиценз олгодоггүй/ бөгөөд зөвхөн ЭМЯ-наас олгодог эмнэлгийн тоног төхөөрөмж ханган нийлүүлэх, импортлох тусгай зөвшөөрөл шаарддаг тул тус эрх бүхий байгууллагаас олгосон барааны импортын лиценз гэсэн шаардлагыг хасаж болох уу?</p>	<p>ТШЗ 20.1-д заасан эрх бүхий байгууллагаас олгосон барааны импортын лиценз, GMP гэрчилгээ, мэргэжлийн байгууллагын чанарын лабораторийн шинжилгээ ирүүлэх шаардлагатай гэсэн ерөнхий шаардлагуудыг хасаж, “Нийлүүлэх барааны хувьд үйлдвэрлэгч, гэрээт борлуулагчийн гэрээ, итгэмжлэл, гарал үүслийн гэрчилгээ, барааны CE, ISO гэрчилгээ ирүүлэх шаардлагатай /шаардлагатай баримт бичгийг баталгаат орчуулгын газраар орчуулуулж, байгууллагын тамга тэмдэг, гарын үсгээр баталгаажуулсан байх шаардлагатай/” гэж өөрчлөв.</p>
2	<p>Гарал үүслийн гэрчилгээ гэж шаардсан байна. Тус тендерийн дагуу нийлүүлэгдэх MRI аппаратыг үйлдвэрлэгчээс худалдан авч Монгол улс руу экспортод гаргахаар үйлдвэрлэгч орны улсын хилээр гаргах үед л гарал үүслийн гэрчилгээ баталгаажин дагалдаж ирдэг тул тус гарал үүслийн гэрчилгээ гэсэн шаардлагыг хасаж болох уу?</p>	<p>Гарал үүслийн гэрчилгээ гэдгийг тухайн MRI аппарат үйлдвэрлэгчийн зөвхөн тус тендерт хандаж, олгосон MAF (Manufacturer Authorization Form) буюу үйлдвэрлэгчийн зөвшөөрлийн маягт гэж ойлгоно. Тендерт санал болгож орсон аппаратын үйлдвэрлэгч, загвар, гарал үүслийг тендерт ирүүлсэн MAF (Manufacturer Authorization Form) буюу үйлдвэрлэгчийн зөвшөөрлийн маягт дээрх мэдээлэлтэй нэгбүрчлэн тулгалт хийж, эцсийн хэрэглэгч ашиглалтад хүлээж авах тул тухайн шаардлагыг хэвээр үлдээв.</p>

3	<p>GMP гэрчилгээ гэж шаардсан байна. Тус гэрчилгээ нь зөвхөн эм үйлдвэрлэгч компаниудад хамааралтай гэрчилгээ бөгөөд тус тендерийн дагуу нийлүүлэгдэх MRI аппарат үйлдвэрлэгч компаниудад хамааралгүй гэрчилгээ тул тус GMP гэрчилгээ гэсэн шаардлагыг хасаж болох уу?</p>	<p>ТШЗ 20.1-д заасан эрх бүхий байгууллагаас олгосон барааны импортын лиценз, GMP гэрчилгээ, мэргэжлийн байгууллагын чанарын лабораторийн шинжилгээ ирүүлэх шаардлагатай гэсэн ерөнхий шаардлагуудыг хасаж, “Нийлүүлэх барааны хувьд үйлдвэрлэгч, гэрээт борлуулагчийн гэрээ, итгэмжлэл, гарал үүслийн гэрчилгээ, барааны CE, ISO гэрчилгээ ирүүлэх шаардлагатай /шаардлагатай баримт бичгийг баталгаат орчуулгын газраар орчуулуулж, байгууллагын тамга тэмдэг, гарын үсгээр баталгаажуулсан байх шаардлагатай/” гэж өөрчлөв.</p>
4	<p>Мэргэжлийн байгууллагын чанарын лабораторийн шаардлагын шинжилгээ гэж заасан байна. Тус тендерийн дагуу нийлүүлэгдэх MRI аппарат нь бусад жижиг эмнэлгийн тоног төхөөрөмж болон эм, эмнэлгийн хэрэгсэл шиг урьдчилж үйлдвэрлэн үйлдвэрлэгчийн агуулахад байнгын бэлэн байдаг бүтээгдэхүүн биш бөгөөд бүх MRI аппарат үйлдвэрлэгчид тендерт шалгарч гэрээ байгуулсны дараа захиалгын дагуу шинээр үйлдвэрлэн тухайн төсөлд нийлүүлдэг бөгөөд MRI аппаратыг зөвхөн үйлдвэрлэсний дараа л шинэчилгээ, тохирлын гэрчилгээ гардаг тул үйлдвэрлэгдээгүй байхад урьдчилан авах ямар ч боломжгүй зөвхөн MRI аппаратыг нийлүүлэх үед дагалдуулж өгөх боломжтой болно. Иймд тус Мэргэжлийн байгууллагын чанарын лабораторийн шинжилгээ гэсэн шаардлагыг хасаж болох уу?</p>	<p>ТШЗ 20.1-д заасан эрх бүхий байгууллагаас олгосон барааны импортын лиценз, GMP гэрчилгээ, мэргэжлийн байгууллагын чанарын лабораторийн шинжилгээ ирүүлэх шаардлагатай гэсэн ерөнхий шаардлагуудыг хасаж, “Нийлүүлэх барааны хувьд үйлдвэрлэгч, гэрээт борлуулагчийн гэрээ, итгэмжлэл, гарал үүслийн гэрчилгээ, барааны CE, ISO гэрчилгээ ирүүлэх шаардлагатай /шаардлагатай баримт бичгийг баталгаат орчуулгын газраар орчуулуулж, байгууллагын тамга тэмдэг, гарын үсгээр баталгаажуулсан байх шаардлагатай/” гэж өөрчлөв.</p>
<p>3. Соронзон резонанст томографийн аппаратын техникийн үзүүлэлт: 13. Угсралт, суурилуулалт, хэрэглэгчийн сургалт: Үйлдвэрлэгчийн Үйлдвэрлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн "Холбогдох үйлчилгээний чадавхийн тухай мэдэгдэл". Тус мэдэгдэл нь дараах 2 мэдээллийг агуулсан байна:</p> <p>1. Дистрибьютер компани нь дээрхи шаардлагуудыг бүрэн хангасан 2-оос доошгүй инженер техникийн ажилтнуудын гэрчилгээнүүд (сургалтын талаарх дээр дурдсан мэдээллийг бүрэн агуулсан) болон үйлдвэрлэгчээс баталгаажуулан ирүүлэх тодорхойлолтыг Гадаад харилцааны яамын консулын газар эсвэл МУ-ын гадаад улс дах консулын газраар дамжуулан баталгаажуулсан байх гэж. заасан байна</p>		
6	<p>Тус “Гадаад харилцааны яамын консулын газар эсвэл МУ-ын гадаад улс дах консулын газраар</p>	<p>Тус техникийн шаардлага нь захиалагчийн талаас олон жилийн туршлага дээрээ үндэслэн гаргасан шаардлага болно. Үүнд: MRI аппаратад гэмтэл гарч, доголдсон тохиолдолд хэвийн ажиллагааг хангахын тулд хэзээ ирэх нь тодорхойгүй,</p>

<p>дамжуулан баталгаажуулсан байх” гэсэн шаардлагыг хууль эрх зүйн хүрээнд нийцүүлж, “Апостиль /Apostille/ хийлгэж баталгаажуулсан байх” гэж өөрчилж болох уу? Монгол улсын Гадаад харилцааны яамны Консулын газраас тус тендерт санал болгох MRI аппаратын үйлдвэрлэгчээс ирэх тодорхойлолт, бичиг баримтыг яаж баталгаажуулж авах талаар лавлахад “зөвхөн Монгол улсаас явуулж байгаа баримт бичгийг л Монгол улсын ГХЯ-ны Консулын газраар дамжуулан баталгаажуулж явуулах боломжтой, харин гадаад улсаас ирэх бичиг баримтыг “Апостиль хийлгэж баталгаажуулж авдаг” гэсэн тайлбар өгсөн.</p>	<p>ямар нэгэн гадаад улсын инженерийн гаргах дүгнэлт, шийдвэрийг хүлээх, гаргасан шийдвэрийнх нь дагуу олон үе дамжлагатай үргэлжлэх процессууд дээр цаг алдахгүй байж, 24 цагийн турш аппаратын үзлэг оношилгоо, засвар үйлчилгээг үзүүлэх чадамж бүхий инженерийн боловсон хүчинтэй байх гэсэн шаардлагыг тусгасан бөгөөд тендерт шаардсан бичиг баримтуудыг Апостилээр баталгаажуулан тендерт ирүүлж болно. Тендерт заасан инженерийн шаардлагыг бүрэн хангасан 2-оос доошгүй инженерийн хувьд шаардсан бичиг баримтуудыг хавсаргахаас гадна: - Монгод улс дах дистрибьютер компанидаа үндсэн ажилтнаар сүүлийн 12 сар тасралтгүй ажилласан байх шаардлагатай.</p> <p><i>ЛШЗ-ийн 18.1-д заасан 3 сарын хугацаанд НДШ төлсөн байх гэснийг 12 сар болгон өөрчлөв/</i></p>
<p align="center">4. Соронзон резонанст томографийн аппаратын техникийн үзүүлэлтийн “10. Coil (Стандарт): Wrist 18 ch – аас багагүй” гэж шаардсан байна.</p>	
<p>7 Энэ бугуйн (wrist) койлыг: “Wrist 12 ch – аас багагүй” гэж өөрчилж болох уу? Учир нь энэ тендерт байгаа бусад койлны үзүүлэлтүүд маш доогуур байгаа боловч зөвхөн бугуйн койлны үзүүлэлтүүдийг өндөр сувгийн тоотой шаардаж байгаа нь Siemens компанийн MRI аппарат санал болгох компанид л давуу байдал олгож байгаа ба Захиалагч эмнэлэгт ач холбогдолгүй шаардлага байна. Бугуйн үений MRI долоо хоногт нэг л тохиолдол орохтой үгүйтэй байхад нуруу нугасны өдөрт 5-10 хүн, толгой өдөрт 8-16 хүн шинжилгээнд ордог ба эдгээр болон бусад олон тохиолдолд ордог шинжилгээний койлнуудын сувгийн тоо Siemens-ээс бусад үйлдвэрлэгчдэд байдаг тооноос илүү бага 10 – 18 ch гэж тавьсан байна. Гэтэл</p>	<p>“Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 12.4. “Техникийн тодорхойлолтод тодорхой нэг аж ахуй эрхлэгчийн бараа, үйлчилгээний худалдааны нэр, патент, түүнийг эзэмшигч, үйлдвэрлэгч, нийлүүлэгч, эсхүл үйлдвэрлэлийн арга, гарал үүслийг тухайлан заахыг хориглоно.” гэж заасны дагуу захиалагчийн зүгээс хуульд нийцүүлэн техникийн тодорхойлолтод шаардсан үзүүлэлтийг давуулж эсвэл дүйцүүлэн санал болгох нөхцөлийг бүрдүүлсэн бөгөөд дэлхийн MRI аппарат үйлдвэрлэгч бүх брэндүүд ижил тэгш өрсөлдөх боломжоор хангаж, бүгдэд нийцэхээр зарласан. Тус техникийн шаардлагыг Philips, Siemens, GE, Toshiba/Canon гэсэн дэлхийн үйлдвэрлэгч нарын дундаж үзүүлэлтэд үндэслэн “Wrist 18 ch – аас багагүй” гэж шаардсаныг “Wrist 16 ch – аас багагүй” гэж өөрчлөв.</p>

<p>толгой, нуруу, цээж, хэвлий болон бусад үенүүдийн койлны сувгийн тоо бусад үйлдвэрлэгчддийнх 15-44 ch байхад, эдгээр койлны сувгийн тоог зориуд Siemens компанийн MRI онцлогт тохируулж, бууруулж, харин ганц бусад үйлдвэрлэгчээс сувгийн тоо нь илүү бугуйн койлыг л зориуд онцолж, “18 ch” гэж бичсэн мэт сэтгэгдэл төрж байна.</p>	
--	--